



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

┌ Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн ┐
сургалт, семинар явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05, 2017 оны 289 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн цэцэрлэгийн хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх, багш, арга зүйчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор цэцэрлэгийн багш нарын “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт сургалт, семинарыг 2019 оны 01 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны V байр, Биеийн тамрын сургуулийн зааланд зохион байгуулсугай.

2. Сургалт, семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, семинарт шаардагдах 2.700.000 /хоёр сая долоон зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.


4. Сургалт, семинарыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2019 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн
1168 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн
сургалт, семинар төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын мөнгө: 5 хоног х 30 цаг х 30.000 төг	900.000 төг
2.	Заалны хөлс:	600.000 төг
3.	Бичиг хэргийн зардал, цай кофе	200.000 төг
4.	Гарын авлага, сурталчилгаа:	800.000 төг
5.	Сертификат хэвлүүлэх	200.000 төг
Нийт дүн		2.700.000

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын 2019 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн А/01 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн сургалт, семинарт хичээл заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|-----------------|----------------------------|
| 1. А.Болдмаа | НБТСХорооны хэлтсийн дарга |
| 2. А.Болорцэцэг | МГХ-ны зөвлөх багш |
| 3. Б.Оргилмаа | Хүүхдийн фитнесийн зөвлөх |
| 4. Ч.Амгалан | "Тэгш бус" ТББ тэргүүн |
| 5. Б.Номин | МГХ-ны дасгалжуулагч |
| 6. Э.Бадамцэцэг | МГХ-ны дасгалжуулагч |
| 7. Ц.Март | МГХ-ны зөвлөх багш |